



**Хэвлэлийн мэдээ**  
2016 оны 10-р сарын 5-ны өдөр

**Холбогдох утас:**  
97109009

## **АмЧам Монгол Гишүүддээ Зориулсан Хөдөө Аж Ахуйн Бизнесийн**

### **Дугуй Ширээний Уулзалтыг Зохион Байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол улс - 2016 оны 10-р сарын 3-нд Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) гишүүддээ зориулсан “Хөдөө аж ахуйн салбар дахь Санхүүжилтийн Боломжууд” сэдэвт дугуй ширээний уулзалтыг АНУ-ын Хилийн Чанад дахь Хувийн Хөрөнгө Оруулалтын Корпораци (ОПИК) Шулц Глобал Инвестмент, болон АНУ-ын Элчин Сайдын Яамтай хамтран зохион байгууллаа.

Уулзалтын үеэр ОПИК-ийн болон Шулц Глобал Инвестмент компаниудын удирдах албан тушаалтнууд дэлгэрэнгүй илтгэл тавьж, уулзалтанд хүрэлцэн ирсэн АмЧамын 20 гаруй гишүүдтэй хэлэлцүүлэг өрнүүлж тэдний сонирхсон асуултуудад хариулж, оролцогчидтой уулзаж танилцсан юм.

Эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарыг цаашид хөгжүүлэх нь АмЧам Монголын бодлогын голлох чиглэлүүдийн нэг юм. АмЧамын Хөдөө Аж Ахуйн Хороо нь гишүүдийн хамтаар салбарын тулгамдаад байгаа асуудлуудыг олж тодорхойлон, шийдвэр гаргах түвшинд буюу Засгийн газартай хамтран бодлогын болон хууль эрх зүйн бодит өөрчлөлтийг бий болгохоор идэвхийлэн ажилладаг юм.

“Хөдөө аж ахуйн салбарын санхүүжилт гэдэг бол Монгол улсын ХАА-ын салбарт хамгийн ихээр тулгамдаад буй асуудал тиймээс ч бид өнөөдөр ОПИК, Шулц Глобал Инвестмент болон АмЧам Монголын гишүүдийн хамтаар энэхүү уулзалтыг зохион байгуулж байгаадаа баяртай байна” хэмээн АмЧам Монголын ТУЗ-ийн дарга Жэймс Лиотта хэлсэн үгэндээ онцлон тэмдэглэсэн юм.

Ажай Рао, ОПИК-ийн дэд захирал, уулзалтын үеэр АмЧам Монгол болон ОПИК-ийн хамтын ажиллагааг онцолж хэлсэн үгэндээ “ОПИК нь АмЧам Монголтой хамтран хөдөө аж ахуйн салбарын бизнесийн төслийг тодорхойлж ЖДҮ-үүдэд санхүүжилтийн шийдэл санал болгохоор ажиллаж байна. ОПИК нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжих замаар Монгол улсын эдийн засгийн төрөлжилтийг дэмжиж, орон нутагт хөдөлмөрлөж буй хүмүүсийн аж амьдралд дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна” гэсэн юм.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.